

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ Э.ФРОММЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Р. Дарьхүү, Ж. Энхжаргал

МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үг: Эерэг эрх чөлөө, сөрөг эрх чөлөө, эгоизм, нарцисизм, садизм, мазохизм, авторитаризм, дескриктивизм, автомат конформизм

Бидний амьдарч байгаа ардчилсан нийгэмд эрх чөлөөний асуудлыг хүн бүр ярьж, хэлэлцэн түүний тухай сайн мэддэг мэт байвч үнэн хэрэгтээ эрх чөлөө хэмээх ойлголтын жинхэнэ утга агуулгыг тэр бүр мэдэхгүй байх хандлага ажиглагдсаар байна.

Эрх чөлөө хэмээх ойлголтын утга, бид ямар нөхцөлд жинхэнэ эрх чөлөөтэй байж чадах вэ?, эерэг болон сөрөг эрх чөлөө гэж чухам юуг хэлэх вэ?, түүний үр дүнд үүсэх байдал зэргийг нарийвчлан судлах шаардлага бидний өмнө тулгарч байна. Энэхүү тулгамдсан асуудлыг Э.Фромм тэртээх 1941 онд анзааран харж “Эрх чөлөөнөөс дайжихуй” зохиолоо туурвижээ. Тэрээр эрх чөлөөний асуудлыг философи, нийгмийн сэтгэл судлалтай холбон тайлбарласан явдал нь анхаарал татаж, Э.Фроммын үзлийг бусад сэтгэгчдийн үзэлтэй харьцуулан судлах нь эрх чөлөөний асуудлыг гүнзгий ойлгоход нэмэр хандив болох болов уу? хэмээн үзэж байна.

Хүмүүст эрх чөлөөний асуудлыг зөв ойлгуулсанаар өөрийнхөө “би”-г алдахгүй байхад нь туслах, мөн эрх чөлөөг хязгааргүй бүхнийг хийх боломж хэмээх өрөөсгөл ойлголтыг засч залруулахад эрх чөлөөний талаархи Э.Фроммын үзэл баримтлал тодорхой хувь нэмэр болно.

Санамсаргүй байдлаар өөрөө аяндаа ямар ч сургаал номлол, философийн урсгал чиглэл, нэрт сэтгэгчид төрөн гардаггүй. Ер нь аливаа нийгмийн хөгжилд улс үндэстний онцлог, хувь хүний үзэл санаа бүрэлдэн тогтоход гадаад болон дотоод хүчин зүйл нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, аливаа хүний үзэл баримтлал төлөвшихөд тухайн хүний амьдарч байсан эрин үе, түүний ойр дотны хүмүүс хийгээд урьд өмнөх алдар цуутай сэтгэгчдийн үзэл баримтлал тодорхой хэмжээгээр нөлөөлж, тэр бүхний эцэст тухайн хүн өөрийн

гэсэн системтэй, нарийн зохион байгуулалттай онол сургаал боловсруулдаг билээ.

Тэрээр Библийн судрууд нь санааны мөнхийн ундрага болдог хэмээн Шульцтай ярилцсан ярилцлагандаа дурьджээ. Ер нь Фроммын ном, зохиолыг судалж үзэхэд тэрээр өөрийн үзэл баримтлалаа ойлгомжтой болгохын тулд библийн судраас нэлээд хэмжээгээр жишээ татсан байдаг.

Буддын сургаал шашинлаг байдлыг тэнгэр бурхангүйгээр авч үзэн хүнийг өөрийг нь гэгээрүүлж, төгөлдөржүүлэхэд чиглэдэг. Энэ байдал нь Фроммын үзэл санаа төлөвшихөд бас багагүй хэмжээгээр нөлөөлжээ. Тэрээр 26 наснаасаа эхлэн буддизмыг сонирхон судалсан төдийгүй, хожим нь Японы Зэн Буддист Сүзүкитэй учирч Зэн буддизмын мэдлэгээ гүнзгийрүүлсэн буй.

Тэрээр И.Я.Бахофены нээлтийн ачаар "түүхийг тайлах, байгуулсан гавьяагаар нь хайрлах зарчимтай манай эрэгчин /эрэгтэй/ иргэншлийг ойлгох түлхүүр"-ийг олж аваад зогсоогүй, мөн өөрийнхөө судалгааны төв асуудлаа ойлгох түлхүүр болжээ. Өөрөөр хэлбэл, хүн энэ нийгэмд хэрхэн биеэ авч явах хэрэгтэй хийгээд хайр сэтгэлийн мөн чанарыг ойлгоход И.Я.Бахофены нээлт Э.Фроммд багагүй нөлөөлжээ.

Э.Фромм анхандаа Фрейдийн сургаалыг талархан дэмжигч байсан төдийгүй, түүний (Фрейдийн) сургаал номлолыг үг дуугүй дагадаг, дуулгавартай шавь байснаа, эцэстээ түүний үзлийн дутагдалтай талыг засаж, улмаар Фрейдийн сургаалыг шинэчлэсэн байна. Тухайлбал, Фромм өөрийн өвчтөнүүдийг эмчлэх явцдаа Фрейдийн эмчилгээний аргыг хэрэглэхэд тэр нь огт үр дүнгүй төдийгүй цаг дэмий үрсэн зүйл болж, өөрийн ажилдаа ч дургуй болох хандлагатай байснаа Фрейдийн сургаал дахь алдаатай зүйлийг олж харснаар тэр байдлыг гэтэлж чаджээ. Тэрээр "Хайрын амт" зохиолдоо "Бэлгийн харилцааны ач холбогдолыг хэтрүүлж үнэлсэнд ч биш, харин бэлгийн харилцааг хангалттай гүнзгий ойлгоогүй байсан учраас би Фрейдийн онолыг шүүмжилсэн юм. Фрейд хувь хүмүүсийн харилцаанд байдаг сэтгэлийн тачаалын ач холбогдолыг нээн харуулах талаар анхны алхам хийсэн бөгөөд түүнийг өөрийн философийн үзэл баримтлалд нийцүүлэн физиологийн талаар нь тайлбарласан. Сэтгэцийн шинжилгээг цаашид хөгжүүлэхдээ физиологийн

хэм хэмжээнээс биологийн болон экзистенциал хэмжээс рүү шилжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх замаар Фрейдийн онолыг завсарлан гүнзгийрүүлэх шаардлагатай болж байгаа юм" хэмээн тэмдэглэснээс нь үзэхэд тэрээр Фрейдийн үзэл баримтлалд хэрхэн хандаж байсан нь тодорхой харагдаж байна.

Мөн түүнчлэн, Фроммын үзэл санаа бүрэлдэн төлөвшихөд Маркс багагүй хувь нэмэр оруулсан бөгөөд тэрээр Марксыг өөрийн багшаа гэж үздэг байжээ. Маркс Фроммд дараахи байдлаар нөлөөлсөн. "Фромм Фрейдийн онолыг тууштай баримтлагч байсан ч яваандаа Марксын философийн нөлөөгөөр Фрейдийн философи дах төрөлхийн ухамсарлагдаагүй дур хүсэл нь бие хүн бүрэлдэн төлөвшихөд голлох нөлөөтэй гэсэн үзэлд шүүмжлэлтэй хандах болж, бие хүний төлөвшилд нийгмийн хүчин зүйл тодорхой хэмжээгээр үүрэг гүйцэтгэдэг болохыг харжээ." Үүнээс гадна К.Маркс Э.Фроммд аливаа зүйлд шашингүйн үүднээс хандахад нь тусалсан гэж үзэж болно.

Э.Фромм эрх чөлөөний асуудлыг сэтгэл зүйтэй холбон үзэж, эрх чөлөөг бид ямар нөхцөлд жинхэнэ утгаар нь эдэлж болох талаар өгүүлсэн буй. Тэрээр "Эрх чөлөөнөөс дайжихуй" зохиолдоо "Улс нийгмийн өнөөгийн хандлага хүн төрөлхтөний агуу гайхамшиг болсон хүний бодьгал шинж, хувь хүний дахин давтагдашгүй нүүр царайг нэгэн хэвийн болгочихож магадгүй аюул нүүрлэж байна. Үүний учир би ... өнөөгийн соёл нийгмийн тулгуур асуудал болох хувь хүний эрх чөлөөний асуудалд анхаарлаа хандуулахад хүрлээ." хэмээн бичжээ. Эндээс харвал хүн өөрөөрөө байх явдал, өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх явдал нь эрх чөлөөний асуудалтай зайлшгүй холбогддог болох нь ажиглагдаж байна. Аливаа хүн өөрөөрөө байхын тулд өөрийгөө хайрлах хэрэгтэй болохыг Фромм дурьдаад харамсалтай нь зарим хүмүүс өөрийгөө хайрлах чадваргүй байдаг тухай өгүүлжээ.

Тэрээр өөрийгөө хайрлах хайрын дутагдлыг эгоизм, нарцисизм хэмээн үзэж, бусадтай харилцах харилцааны доголдлыг садизм, мазохизм хэмээн тайлбарласан буй.

Мөн Фромм нарцисизм, эгоизм хоёрыг шунахай зангийн илрэл гэж үзсэн. Энэ үзэгдлийг Палестинд байдаг нэг "Ширгэсэн нуур"-тай зүйрлэж

тайлбарлажээ. Тэр нуур бусад нууртай адил олон цутгалантай байсан боловч нэг ч гол түүнээс урсан гардаггүй байсаар ширгэж алга болжээ. Үүнтэй адилхан эгоист хийгээд нарцисист хүн зөвхөн өөрийгөө бодож, хар амиа хичээсээр байгаад эцэстээ эгээ л "ширгэсэн нууртай" адил болох талтай. Ийм хүнийг нэгэн бодлын паразит амьдралтай шумуултай зүйрлэж болно.

Энэ тухай Фрейдийн сургаалд өгүүлэхдээ: "Ер нь ажиглаж байхад хүний психологид их харагддаг өөрийгөө их бодож, шохоорхдог нарцисист, эгоист шинж олон түмний психологид илэрдэг. Ялангуяа өөрийн шүүмжлэл багатай ард түмэнд энэ нь их тод харагддаг. Хувь хүний нарцисист-эгоист шинж нь олон түмний психологид очихоор тухайн улс үндэстэн өөрсдийгөө хэт их магтах, бусад үндэстэн ястанг үл тоомсорлох, өөрсдийн байгаа байдлыг хэт дөвийлгөн бусдын байдлыг зориудаар дор үзэх байдал илэрдэг". Хэрэв нийгэмд ийм байдал хэт даамжирвал нэгэн дэлхий дээр амьдарч байгаа улс үндэстнүүдийн хоорондын харьцаа хүйтэрч, улмаар еврейчүүдийг / жүдүүд / ялгаварлан гадуурхсан Гитлерийн засаглалыг давтах аюултай юм. Тэд өөрсдийгөө бүхнээс илүү ухаантай, хүч чадалтай, би л гэсэн сэтгэлгээтэй байснаас ийм эмгэнэлтэй байдалд хүрснийг бид бүгдээрээ санаж байгаа. Тэд ийнхүү эрх чөлөөний мөн чанарыг өрөөсгөл буруугаар ойлгожээ.

Ер нь эгоист болон нарцистууд өөрийгөө хайрлаж, хамаг оюун санаа нь дотогшоогоо чиглэчихсэн байдаг тул түүнд бусадтай харилцах харьцааны доголдлоос сэтгэцийн гажиг эмгэгт хүргэдэг.

Түүнчлэн аливаа хүн өөрийгөө үнэлдэггүй, хайрлаж чаддаггүй байдгаас баг өмссөн "би" төрдөг. Угтаа бие хүн бол нийгэмд эзлэх байр сууриа бататгах, өргөмжлөх, шунахайрахын л илрэл болсон гэж Фромм тэмдэглэжээ. Өөрөө хэлбэл, нийгэмд өөрийгөө өргөмжлөгчид хэт ихсэх нь нийгмийг "би" гээчийн өвчнөөр өвчлүүлж би л болж байвал боллоо гэсэн харалган байдлыг нийгэмд үүсгэнэ. Хэрэв ийм байдал даамжирвал хүн төлөрхтөн өөрсдийгөө хөгжүүлэх асар их боломж бололцоог алдахаас гадна Фроммын үздэгчлэн нийгэм өвчлөх болно.

Харин ийнхүү нийгмээ өвчлүүлэхгүй байхын тулд бидний хийх нэн түрүүний алхамыг Фромм эрх чөлөөнд хүрэх явдал хэмээжээ. Үнэхээр ч тэрээр

эрх чөлөөг олоход учирч буй ганцаардал, айдас түгшүүр зэргийг даван туулж, идэвхтэй хөдөлмөрлөж, өөрийгөө өөрчилж, оюун санаагаа дайчилсан хүн л эрх чөлөөний амтыг мэдрэх юм гэж үзсэн.

Эрх чөлөөг ойлгох ёс суртахууны харилцаа гагцхүү хүмүүсийн өөр хоорондоо сайн санаагаар харилцах явцад илрэх бөгөөд энэ харилцаа энэрэл, хайр, оюун ухааны үндсэн дээр албадлагагүй дэлгэрнэ" гэжээ. Эндээс үзэхэд бид эрх чөлөөг байнга хамгаалж хөгжүүлж байх шаардлагатай юм. Тэгж чадахгүй бол эрх чөлөө алдагдах болно. Бид ус, агааргүй амьдарч чадахгүй адил эрх чөлөөг хайрлаж, тордож хамгаалахгүйгээр эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжих боломжгүй юм.

Аливаа хүний идэвхгүй байдал, асуудлыг шийдвэрлэх гэж оролдохын оронд хэн нэгний ард орж нуугдах, өөрийнхөө өмнөөс бусдад хариуцлага үүрүүлэх гэсэн идэвхгүй, хүнийг алмай, дорой арчаагүй байдалтай болгохын зэрэгцээ эдгээр үйлдлүүд нь бүгд эрх чөлөөнөөс дайжихад чиглэсэн алхмууд болохыг ойлгож ухаарах болно. Цааш нь Фромм эрх чөлөөнөөс дайжих хандлагуудыг авторитарист, дескриктивист, автомат конформист зэрэг хэлбэрүүдэд ангилсан.

Фроммын үзлээр, авторитаризм нь анхдагч холбооноос холдож, түүнээсээ салсан хүн өөрийгөө хэн нэгэн хүнтэй эсвэл ямар нэг зүйлтэй салшгүй холбоотой гэж авч үзэх явдал юм. Энэхүү авторитарист хандлага нь дотроо мазохизм, садизм гэсэн хоёр үндсэн төрөлтэй.

Мазохизм нь: - Хүн өөрийнхөө "би"-ээс татгалзаж, улам жижгэрэхэд чиглэсэн зовж тарчлахыг зорилгодоо хүрэх хэрэгсэл болгогсод

- Ямар нэг хүчирхэг агуу зүйлийн нөмөр нөөлөгт багтан түүнийхээ нэг хэсэг болохыг тэмүүлэгчид хэмээх хоёр хэлбэртэй ажээ. Жишээлбэл, аливаа зүйлийг бие даан шийдвэрлэх чадваргүй, ямагт хэн нэгний амыг харж амьдрагсадыг мазохист хандлагатангууд гэж хэлж болох юм.

Харин садист хандлага нь:

-Бусдыг юу ч хийж болох зуурмаг мэт үзэгчид

-Бусдаас сорж болох бүх шим шүүсийг нь сорогчид

-Бусдын зовж тарчлахыг харахыг хүсэгчид зэрэг илрэх хэлбэрийн хувьд гурван янз байх юм. Тухайлбал, садист хандлагатай хүмүүс өөрийн хүчин мөхөс байдлыг даван туулахын тулд бусдыг хүчээр дарамтлан, өгөөмөр буянтны дүрийг ч эсгэх чадвартай боловч тэд бусдын эрх чөлөөг үгүй болгохыг эрхэмлэдэг

Мөн түүнчлэн садист болон мазохист хандлагатай хүмүүс нь асуудлыг шийдвэрлэхийн оронд хэн нэгний ард орж нуугддаг нь тухайн үеийн бэрхшээлтэй байдлаас түр ангижрахаас бус, асуудлыг шийдвэрлэж чадахгүй. Энэхүү садист, мазохист хандлагыг зүйрлэвээс шүд нь өвдсөн хүн тухайн өвчилсөн шүдээ эмчлүүлэхийн оронд түр зуур өвчин намдаах эм хэрэглэн өвчнөө улам сэдрээхтэй адил юм.

Ганцаардал, хүнийсгэл, өөрийн хүчин мөхөс байдлаасаа ангижрахын тулд эвдэн сүйтгэх хандлага үүсдэг бөгөөд үүнийг Фромм дескрутивизм хэмээн нэрлэдэг. Дескрутивист байдлаар амьдрагсад нь эрх чөлөөнөөс дайжихад чиглэсэн нэгэн алхам болно. Дайсагнах эвдэн сүйтгэх хандлагатай хүмүүс хувь хүний мэдрэхүй, сэтгэл хөдлөл, оюун сэтгэхүйг хүчээр дарамталснаас үүдэлтэй таагүй байдлын ул мөр юм. Сүйтгэгч бие хүний онцлог нь бусдыг устгах, ангижрахыг эзэрхийлдэг бол садистууд өөрийн эрхшээлд орогсдыг хараанаас ангид байлгахыг хүсдэггүй, тэднийг дарамтлахыг урьтал болгодог бөгөөд хэрэв тэрхүү холбоо нь тасрахад хүрвэл эмгэнэн гашууддаг байна.

Энэхүү байдлыг дараах байдлаар илэрхийлье: Сэтгэл зүйн хувьд мазохист болон садист хандлагатай хоёр хүн ойд явж байгаад шувуу барьжээ. Тэр хоёр адилхан шувуу барьсан боловч эвдэн сүйтгэх хандлагатай хүмүүс барьсан шувуугаа шууд хороохыг хүсдэг бол садистууд барьсан шувуугаа торонд хийж өөрийн эрхшээлдээ оруулахыг урьтал болгодог.

Цааш нь, Фромм эвдэн сүйтгэх хандлагад хөтлөх хоёр төрлийн сэдэл (тухайн нөхцөлд өөрийнх нь хийгээд ойр орчных нь хүмүүсийн амьдрал амьдралынх нь утга учир болсон үзэл бодолд шууд заналхийлсэн үед хамгаалах үүднээс сүйтгэх үйлдэл хийх явдлыг буруутгаж үзээгүй, харин ямар ч ноцтой шалтгаангүйгээр зарим хүмүүс сүйтгэгч авир гаргадаг үүнд Фромм

шүүмжлэлтэй хандсан) байдаг гэж үзээд, хүний амьдралын төлөөх тэмцлийн эрч буурсан нөхцөлд эвдэн сүйтгэх хандлага улам бүр газар авдаг хэмээжээ.

Эвдэн сүйтгэх хандлагатай хүмүүс өөрийнхөө өрсөлдөгчтэй өрсөлдөж амжилтанд хүрье гэж тэмүүлэхийн оронд бусдад атаархаж, эгээ л түүнийг хэрхэн хорлох тухайгаа бодож дэмий л өөрийгөө хөгжүүлж болох алтан цагаа үр ашиггүй үрдэг. Тэд өрсөлдөгчид өөрсдийг нь хурцалж, хөгжүүлж байдгийг ойлгодоггүй. Улмаар эвдэн сүйтгэх хандлагатай хүмүүс тухайн хүндээ хор учруулж чадахгүй бол өөрийгөө хөнөөх арга замыг сонгодог нь эмгэнэлтэй.

Эрх чөлөөнөөс дайжих дараагийн алхам нь конформист хандлага болохыг Фромм тэмдэглээд, өөрийн хувь хүний онцлог шинжээ алдах замаар нийгмийн зүгээс шаардаж байгаа тэр дүр төрхөд хувиран орох замыг сонгогчид нь автомат конформист хандлагатангууд болох юм гэжээ. Энэ хандлага нь дээр өгүүлсэн садист, мазохист, устган сүйтгэх хандлага зэргийн нэгэн адил жинхэнэ эрх чөлөөнөөс татгалзах хүний үйлдэл мөн. Ийм хүмүүс нийгэм маань шаардаж байгаа учраас гээд л өөрийн сэтгэл, оюун ухааны шийдвэрийг харгалзахгүйгээр өөрөө өөрийнхөөрөө байх боломжуудаа алдаж байгаа үйлдэл юм. Иймэрхүү хүмүүсийг гадаад орчныхоо өнгө төрхөд хувирагч хамелонуудтай зүйрлэж болно. Тэдний жинхэнэ өнгө төрхийг бид хэзээ ч мэдэж чаддаггүй, тэр ногоон өнгөтэй ургамал дээр байвал ногоон болж, саарал өнгөтэй зүйл дээр очвол саарал болж хувирна.

Нийгэмд иймэрхүү байдал даамжрах нь хүмүүсийг эгээ л робот адил болгон хувиргах аюултай юм. Робот бол ганцаардах, өөрийн хүчин мөхөс байдлаа ухамсарладаггүй, нэгэн бодлын амар мэт боловч хүн үүнд ямар программ суулгасан байна түүнийг л дагадаг идэвхгүй, нэгэн программчлагдсан схем юм. Эндээс харахад ганцаардал, өөрийн хүчин мөхөс байдлаасаа ангижрах нэгэн арга нь зүгээр л нийгмийн захиалгат автомат төхөөрөмж болох явдал ажээ. Тэгвэл хэзээ бид энэхүү арчаагүй байдлаа даван туулж сайн сайхан эрх чөлөөтэй амьдрах болоцоотой вэ?

Амьдралын дүр зургаа оюун ухаандаа дүрслэн буулгачихаад түүнийхээ төлөө шийдвэртэй алхамуудыг хийж, аливаад хариуцлагатай хандах нь хүнийг

аз жаргалтай, сайн сайхан, эрх чөлөөтэй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ бүхэн эерэг эрх чөлөөнд хүрэх зам юм.

Эерэг эрх чөлөө гэдэг бол хувь хүн соёл болон нийгмийн төрөл бүрийн дарамтнаас өөрийнхөө нөөц бололцоог дайчлан, өөрийн онцлог байдал чадавхийг хөгжүүлэн, өөрийн гэсэн онцлог шинжээ хадгалж үлдэх боломж гэж Оксфордын "Философийн толь бичиг"-т дурьджээ. Фромм хүний хөгжилд эерэг эрх чөлөөний асуудлыг онцлон авч үзэхдээ дээрхтэй төсөөтэй байр суурийг баримталсан бөгөөд эерэг эрх чөлөө нь аливаа хүн бусадтай тогтоосон холбоо харилцаагаа алдахгүйгээр тусгаар эрх чөлөөтэй давтагдашгүй онцлогтой байх боломж гэжээ. Өөрөөр хэлбэл, түүнийхээр хүн өөрийгөө ертөнцийн салшгүй нэг хэсэг гэж үзэхийн зэрэгцээ мөн ертөнцөөс хамааралгүй хувийн чөлөөт байдлаа мэдэрч байвал тэр нь эерэг эрх чөлөө мөн. Ер нь эерэг эрх чөлөө нь хувь хүн амьдралдаа өөрийнхөө сайн дураар идэвхитэй хандах, өөрийн авьяас чадварыг дээд зэргээр хөгжүүлэхийг шаардаж байдаг. Эндээс бид эерэг эрх чөлөөнд хэрхэн хүрэх вэ? Бид жинхэнэ эрх чөлөөтэй байж чадах уу? ийм боломж бололцоо бидэнд байгаа юу гэсэн асуулт бидний өмнө тулгарах болно. Эдгээр асуултанд Э.Фромм боломжтой хэмээн хариулжээ. Үүний тулд бид дараахи зүйлийг хийх хэрэгтэй аж. Үүнд:

1. Аливаа хүнийг өөрийнхөөрөө байх бололцоог олгодог, нэн түрүүнд өөрийн гэсэн нэр төрөө хадгалах хамгийн наад захын боломжийг дур зоргоороо авирлах явдал олгодог хэмээн Э.Фромм үзсэн төдийгүй, хүн байгаль хоёрыг холбогч сэжим хэмээжээ.

2. Эерэг эрх чөлөөнд хүрэх дараагийн алхам бол цочмог үйлдэл хэмээн Фромм үзсэн. Тэрээр үүнийгээ тодруулж урьд, хожид үзэгдээгүй сайхныг үзэх, удаан хугацаанд эрж хайснаа гэнэт олох, онцгой сонин гойдыг мэдрэх, ямар нэг шагнал хүртэх, хэн нэгнээс гэнэтийн бэлэг авах, эсвэл хэн нэгэнд сэтгэл алдах гээд бидний амьдралд цочир үйлдэл шаардсан баярт мөчүүд тохиолддог нь өөрийн "би"-г бүрэн дайчилж, хүрээлэн буй ертөнцтэй холбогдож чадсанаараа ганцаардлаас ангижрах, амьдралд өөрийн гэсэн байр сууриа эзэлж, амьдралын утга учрын талаархи эргэлзээнээс салахад тус дөхөм болох юм хэмээжээ. Ер нь хүмүүс цочмог үйлдэл хийх тоолондоо гадаад

орчинтойгоо нэгдэн нягтарч тэр бүрдээ өөрийн өнгө төрхөө улам бүр засдаг аж.

3. Жинхэнэ хайрын утга учрыг ойлгосноороо хүн өөрийнхөөрөө байх боломжийг олоод зогсохгүй, бусдыг ч өөрийнхөөрөө байх боломжийг бүрдүүлж өгөх бөгөөд энэ нь эрх чөлөөнд хүрэх нэгэн алхам юм. Э.Фромм хайр гэж чухам юуг хэлэх, хайр сэтгэлийн мөн чанар юунд орших вэ? гэсэн асуултанд "Хайрын амт" зохиолоороо хариу өгсөн байдаг. Тэрээр "Хайр сэтгэл гэдэг бол хүнд байдаг идэвхитэй хүч, хүнийг ойр дотны хүмүүсээс тусгаарлаж байгаа тэр ханыг эвдэж, түүнийг бусад хүнтэй нэгтгэж байдаг хүч мөн. Хайр сэтгэл нь бусдаас таслагдсан ганцаардмал байдлын сэтгэлгээнээсээ ангижрахад туслахын хамт хүн өөрөө өөрийгөө эзэмдэж бие даасан байдлаа хадгалах боломжийг олгоно". Иймд өөрийгөө болон бусдыг хайрлах чадвартай хүн эерэг эрх чөлөөнд хүрч чадах юм.

4. Хүн өөрийн хүч бололцоог дайчлан хөдөлмөрлөж байж л бусдад өөрийгөө нээн илрүүлэх чадвартай болох бөгөөд унжаад байхаар унаад ирээсэй гээд хэвтэх нь тухайн хүнийг улам бүр арчаагүй болгоод зогсохгүй, хэн нэгний гарыг харж амьдрах дорой идэвхгүй нэгэн болгох муу талтай. Иймээс хүмүүс идэвхитэй хөдөлмөрлөж, өөрийнхөө үзэл бодлыг бусдад чөлөөтэй илэрхийлж, өөрийн гэсэн хүсэл зорилготой байсан цагт эрх чөлөөнд хүрч болно. Фромм дээрх санааг дараах байдлаар илэрхийлжээ. Хүн нийгэмд өөрийн гэсэн тодорхой орон зайтай байж, бусдад өөрийгөө нээн илэрхийлэх боломжийг хөдөлмөр олгодог төдийгүй, идэх, уух, өөрийгөө хөгжүүлэх боломжийг хөдөлмөр хүнд олгодог гэж үзсэн.

5. Аливаад хичээл зүтгэлтэй хандвал хүн сайн сайханд хүрч болно гэсэн санааг Фромм хүний идэвхи зүтгэлтэй холбон тайлбарлажээ.

Хүн төрөхдөө бүгд тэгш эрхтэй байдаг ч тэдний чадварууд хоорондоо харилцан адилгүй байдаг. Эндээс үзвэл, хүн эхээс мэндлэхдээ бүгд нэгэн гараанаас эхэлдэг боловч тэдний чадварууд харилцан адилгүй тул бүгд нэгэн адил амьдардаггүй гэсэн үзэл ажиглагдаж байна. Энэ нь Фромм хүмүүст ялгавартай ханддаг юмуу гэсэн сэтгэгдэл төрүүлж болох боловч үнэхээр ч мэлхий хичнээн хүссэн ч шувуу шиг тэнгэрт дүүлж чадахгүйтэй адилхан.

Үүнтэй төсөөтэй санааг эртний Хятадын философич Жуанз илэрхийлэхдээ: Нугасны хөл богино бөгөөд бид уртасгая гэвэл нугасанд зовлон болно. Тогорууны хөл урт бөгөөд хэрэв бид түүнийг богиносгоё гэж оролдвол тогоруу гомдох бөгөөд угаас уртыг богиносгож, богиныг уртасгаж болохгүй. Үүнтэй адил хүний уг чанарт тохирохгүй, чадвараасаа хэтэрсэн зүйлд тэмүүлэх нь биднийг баг өмсгөн өөрийн мөн чанараараа байх боломжийг алдагдуулах юм. Ийм учраас хүн бүр өөрийгөө бусдаас ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрч тэр ялгагдах шинжээ хөгжүүлэх хэрэгтэй.

Эерэг эрх чөлөөнд хүрэх таван алхмын тусламжтайгаар хүн санаж тэмүүлсэндээ хүрэх төдийгүй, үүнийгээ дагаад нийгэм маань эрүүлжин хөгжих үндэс суурь нь тавигдана.

Фроммын дээрх үзэлтэй ойролцоо байр суурийг түүнээс өмнө Милль баримталжээ. Милль либерализмын төлөөлөгч байсны хувьд хүний эрх чөлөөтэй байх явдалд гүнээ итгэдэг. Тэрээр “Эрх чөлөөг юмс сайжрах гарцаагүй байнгын эх сурвалж” гэж үзээд, үүнийгээ дараах байдлаар хэрэгжүүлж болно гэж үзсэн. Үүнд:

1. Хүмүүс бие биенийхээ үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж, бусдыгаа буруу зүйл хийж байвал түүнийг албадлагын бус замаар ойлгуулах үндсэн дээр бие биедээ туслах хэрэгтэй.

2. Хүмүүс сонгох эрх чөлөөтэй байх хэрэгтэй. Ингэх нь хүн өөрөөрөө байх хийгээд хүний мөн чанар хөгжихөд багагүй нөлөөлнө. Ийм санааг “Дэлхийн ном”-нд дараах байдлаар илэрхийлсэн байдаг. “Эрх чөлөө гэдэг бол сонголт хийх чадвар бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэх боломж” гэжээ. Мөн үүнтэй төсөөтэй байр суурийг орос америкийн эрдэмтэн С.Левицкий “Эрх чөлөөний эмгэнэлт байдал” номондоо тусгасан. Түүний үзлээр, “Зүйд нийцэх эс нийцэхийн шалгуур тодорхойгүй байхад нэгийг шилэх шаардлага тулгарах шиг хэцүү зовлонтой зүйл байхгүй. < Сэтгэл зүрхнийхээ дуудлагад итгэ. Тэнгэрээс баталгаа байхгүй > Юу гэвэл нэгийг шилж сонгоход хариуцлага хэрэгтэй, ямар ч атугай үл мэдэгдэх юманд аюул осол бий. Нэгийг шилэхээс татгалзана гэдэг бол сөрөг зүйл шилсэнтэй адил юм.” Тухайлбал: Тамирчин хүн тэмцээнд

оролгүй би хожигдчих байх гээд айгаад суух нь тэр хүнийг улам зэврүүлдэгтэй адил бид аливаа зүйлд ухаалаг сонголт хийж хариуцлагатай хандах хэрэгтэй.

3. Хүн бүрт өөрийн гэсэн туршлага байдаг, тэрхүү туршлагуудаа улам өнгөлөн зүлгэх нь нийгмийн дэвшлийг авчирна. Миллийн энэ санаа нь Фромм, Жуанз нарын хүн бүр өөрийн гэсэн бусдаас ялгарах онцлог шинжүүдтэй бөгөөд түүндээ таарсан үйл ажиллагаа явуулах хэрэгтэй гэсэн үзэлтэй төсөөтэй. Тухайлбал: Фроммын эрх чөлөөнд хүрэх тав дахь алхамтай ойролцоо санааг илэрхийлжээ.

Тэгэхлээр Милль хүн эрх чөлөөтэй байснаар өөрөө өөртөө үнэт зүйл болоод зогсохгүй, бусдын хувьд үнэт зүйл болно гээд, эрх чөлөө бол хүн төрөлхтний аз жаргалын боломжуудыг өөртөө агуулагч юм гэсэн нь хүнийг идэвхитэй амьдрах хэрэгтэй гэж сургасан мэт.

Өмнө өгүүлсэн зүйлийг дүгнэж үзвэл, аливаа хүн эрх чөлөөтэй байхын тулд, эрх чөлөөнд хүрэхийн тулд хэн нэгний ард орж нуугдах бус, харин бүхий л хүч боломж бололцоогоо дайчлан идэвхитэй хөдөлмөрлөж, өөрийгөө болон бусдыг хайрлах чадвартай байхын зэрэгцээ аливаад ухаалаг хандаж, хариуцлагатай сонголтын алхмуудыг хийх хэрэгтэй юм. Эцсийн дүндээ жинхэнэ эрх чөлөөнд хүрэх зам бидний гарт байдаг бөгөөд бид амьдралдаа идэвхитэй хандаж чадсанаар түүнийг олж авдаг. Өөрөөр хэлбэл, эрх чөлөө хэмээх ардчиллын үнэт зүйл бидний өмнө байдаг ба бид түүнийг арчлан тордож, хайрлаж чадсан тохиолдолд сая түүний жинхэнэ утга учрыг ойлгох болно. Мөн түүнчлэн эрх чөлөө гэсэн үг нь бие даасан байдал, ухаалгаар оршин байх боломжуудыг хайрладгийн зэрэгцээ, өөрийн авьяас чадварыг дээд зэргээр хөгжүүлэх боломж бололцоог олгодог болохыг өгүүлсэн байна. Энэ бүхнээс эрх чөлөө гэдэг нь чухамдаа ажил хэрэг бөгөөд, нөгөө талаас дадлага туршлага, сайн дурын бүтэц зохион байгуулалт, өөрийгөө бусдаас ялгах онцлог шинжүүдээ өнгөлөн зүлгэх өөрийгөө дээд зэргээр хөгжүүлэх боломж бололцоо юм.

- Г.Вольф. Улс төрийн философийн удиртгал УБ. 2002
С.Левицкий "Эрх чөлөөнөөс айх сэтгэл"- Бодрол бясалгал сэтгүүл. УБ. 1992
№7
Фрейд. Психоанализ УБ. 1998
Э.Фромм. Хайрын амт УБ. 1995
Э.Фромм. Эрх чөлөөнөөс дайжихуй УБ. 2002
Фэн Ю-Лань. Хятадын философийн товч түүх. УБ. 2000
Эрх чөлөө ба философи УБ. 2000. №6
Д.Содномгомбо, Р.Дарьхүү. Философи. УБ. 2004
Р. Дарьхүү, Г. Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ. 2004

* * * * *

- Э.Фромм. Бегство от свободы. Минск. 1998
Э.Фромм. Иметь или быть. Минск. 1990
Э.Фромм. Психоанализ и этика. Минск. 1998
Чжуанз Цзы – Древнекитайская философия. Т1.М.1972
Oxford Dictionary of Philosophy. Shanghai. 2001
Stumpe. Philosophical Problems. New York. 1994
World book №7. USA. 1995

Hyperlink

www.promttheusbooks.com

www.philosophypages.com